



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2002 оны 05 дугаар

Дугаар 21

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

“ЧИНГИС ХААН” ОДОН БИЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Чингис хаан” одон бий болгосугай.

2. “Чингис хаан” одонгийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар, тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. /1 дүгээр хавсралтыг Улсын Их хурлын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 56 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон./

3. “Чингис хаан” одонг Их Эзэн Чингис хааны өдөр буюу Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгож байсугай. /Энэ заалтыг Улсын Их хурлын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн тогтоолоор нэмсэн./

4. “Чингис хаан” одонд нэр дэвшүүлэх, шагнах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосугай. /Энэ заалтыг Улсын Их хурлын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн тогтоолоор нэмсэн./

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА
С.ТӨМӨР-ОЧИР